

БАГШИЙН ХӨГЖЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Ю.Байгалмаа¹, Г.Энхцэцэг¹, Т.Энхмягмар¹, Ц.Дэлгэрмаа¹, Ц.Эрдмаа²

¹АШУУИС-Дорноговь аймаг дахь салбар АУС

²АШУУИС-Дархан-Уул аймаг дахь АУС

Baigalmaa.yu@ mnums.edu.mn

Удиртгал:

Монгол орон зах зээлийн ардчилсан, хүмүүнлэг иргэний нийгэмд шилжиж эхэлсэн өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд хүмүүсийн болон нийгмийн амьдралд асар олон өөрчлөлт, шинэ зүйл бий болсоор ирсэн билээ. Нэг талаас нийгмийн шинэ шатны өөрчлөлт, хөгжилт нөгөө талаас мэдээлэл технологийн асар хурдтай, өргөн мэдээлэлтэй холбоотой юм. Энэхүү өөрчлөлт, шинэчлэлт, хөгжилд хүмүүсийг зөв чиглүүлж, сургаж, хүмүүжүүлэх ажилд боловсролын байгууллагын тэр тусмаа багшийн үүрэг, үйл ажиллагаа, хариуцлага, хөдөлмөр хамгийн чухал байр суурь эзлэх нь тодорхой.

Хөгжлийн зарим асуудалд:

Монгол улсын хөгжил хүнээ хөгжүүлэхээс, хүнээ хөгжүүлэх нь боловсролын хөгжлөөс, боловсролын хөгжил багшаа хөгжүүлэхээс шууд хамаардаг болохыг эрдэмтэд онцолсоор байна. Тухайлбал: акад.Б.Жадамбаа, проф.Ц.Батсуурь, проф.Б.Пүрэв-Очир, проф.Д.Пүрэвжав нар “Багш боловсролын ирээдүй” бүтээлдээ “Боловсролын хөгжил нь олон хүчин зүйлээс шалтгаалах боловч түүний гол цөм нь БАГШИЙН ХӨГЖИЛ болох нь хэнд ч эргэлзээгүй юм. Багш олон талаар хөгжиж чадаж гэмээнэ боловсролын менежмент, орчин, нийгмийн болон хувь хүний боловсрох үйл явц, түүний хөтөлбөр, үнэлэмж, чанар гэх зэрэг бусад элементүүд нь дагалдан хөгжих ёстой,” хэмээн тэмдэглэжээ.

Багшийн тухай үндсэн ойлголтын талаар:

Багшийн талаар эрдэмтэдийн гаргасан олон тодорхойлолтуудаас заримыг нь дурьдвал: проф.Ц.Балхжав “Багш” хэмээх номондоо “Багш нэр уг нь хүмүүжүүлэх сургах, заах, боловсруулах гэх мэт үгсийн гаралтай билээ гээд “Багш” нэр бол эцэг эх гэдэг шиг манай гариг дээрх аль ч улс оронд түгээмэл алдар цуутай үг. Энэ нэрийг хүн болгон эзэмшдэггүй, харин түүнийг юуны өмнө эрдэм ном, хүмүүжил, сургалттай холбодог” хэмээжээ. Боловсрол судлалын шинжлэх ухааны доктор, проф. Ч.Пүрэвдорж “Багшлахуйн менежмент” бүтээлдээ “Багш шавиа эцэг эх лүгээ энэрэн хайрлаж, номын увидсыг сургах, шавь нь багшаа хүндэтгэн биширч, номд хичээнгүйлэн суралцах ёстой” гэжээ.

Боловсрол судлалын ухааны доктор Ш.Ичинхорлоо “Багшийн ном” бүтээлдээ “Багш гэдэг нь өсвөр залуу үеийнхэнд амьдрал ахуйд

нь хэрэгтэй мэдлэг, арга барил, чадвар, туршлага олж авахад нь туслах, тэднийг иргэн-бие хүн болон хөгжин төлөвших, нийгэмших, ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион явуулах ур чадвар бүхий бие хүн юм” гээд “Багш бие хүний үндсэн чанар гэсэн ухагдахуун шинжлэх ухаанд байдаг.

Үүнд:

Ажилдаа дур сонирхолтой, идэвхи санаачлагатай, шинийг хийж-бүтээх эрмэлзлэлтэй, хариуцлагатай, уян хатан сэтгэдэг, ажилдаа сэтгэлээ зориулдаг, Шударга, Хүмүүнлэг, Өөрийгөө эзэмддэг, хянадаг, Хурдан сэтгэдэг, Аливаад ухаалаг ханддаг, Тэвчээртэй, Хүлээцтэй, Өөрийн сурган хүмүүжүүлэх арга барилтай, Шавь нараа чин сэтгэлээсээ хайрладаг, хүндэлдэг, Суралцагчдад бүх талаараа үлгэр жишээ үзүүлдэг, Өөрийгөө дайчилдаг, шаргуу, Мэргэжлийнхээ нэр төрийг эрхэмлэдэг, Урлаг, спорт гэх мэт олон талын мэдлэг, чадвартай байх, Хууль журмыг хүндлэн сахидаг, Өөрийн эрх мэдлээ урвуулан ашигладаггүй байх чанарууд багтана” гэжээ. Иймд БАГШ хэмээх эрхэм алдрыг зүүж, түүний нэр хүнд, үүрэг хариуцлагыг дааж явна гэдэг нь багшийн ажил, үйлийг хийж байгаа хэн бүхний байнга өөрийгөө хянаж, үг яриа, үйл хөдлөл, дүр төрхөө анхаарч явах хариуцлага юм.

Багшийн хөгжлийн зарим асуудал:

Хүн төрөлхтөний нийгмийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь боловсрол бөгөөд боловсролын хөгжлийн цөм нь БАГШИЙН ХӨГЖИЛ юм. Багшаа хөгжүүлж өөрчлөхгүйгээр боловсролын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх боломжгүй.

Багшийн хөгжил гэдэг нь тухайн нийгэм, соёл, бусад багш нар, суралцагч, эцэг, эх, олон нийт мэргэжлийн орчинд орж, өдөр тутам харилцаж, хамтран ажиллаж байгаа хувь хүний өөрөө хөгжих явц юм.

Багшийн хөгжил-Багш нь хүнийг сургаж, хөгжүүлдэг хүний хувьд өөрөө байнга суралцагч, хөгжигч байх ёстой.

Багшийн өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа нь олон чиглэлтэй:

1. Багш хүн өөрийнхөө мэдрэмжийг хөгжүүлэх,

А. Цаг үеэ мэдрэх мэдрэмж

Багшийн амьдарч буй цаг үе, нийгэмд асар их өөрчлөлт гарч байгааг мэдрэх мэдрэмж,

Б. Шинэ зүйлийг мэдрэх түүнийг хүлээн авах мэдрэмж

Мэргэжлийн хичээл, Сэтгэл судлал, СХУ-д

ямар шинэ үзэл санаа, өөрчлөлт гарч байгааг мэдэрч, эдгээрт дүн шинжилгээ хийх, шинэ мэдээллийг хүлээн авахад нээлттэй байх, өөрийнхөө мэргэжлийн үйл ажиллагаанд тусган ажилдаг байх,

В. Багшийн зүгээс сурагчаа мэдрэх мэдрэмж

Энэ нь сурагчийн хүсэл сонирхол, хэрэгцээ, түүний ертөнцийг үзэх үзэл бодол, сэтгэл санаа, бие бялдар, ёс суртахуун зан үйлд гарч буй их бага бүхий л өөрчлөлтийг мэдрэх,

Г. Багш ажлынхаа үр дагаврыг мэдрэх мэдрэмж

1. Багш хүн өөрийнхөө хэлсэн үг, хийж буй үйлдлийн нөлөө, үр дагавар, үр дүнт мэдрэх мэдрэмж,

2. Сурган хүмүүжүүлэх ажилдаа хандах хандлагаа өөрчлөх,

3. Багш өөрийнхөө сурган хүмүүжүүлэх ёс зүйн харилцааны соёлоо төгөлдөржүүлэх,

4. Сургалтын хөтөлбөр хийх,

Орчин үед дэлхийн олон оронд багшийн найдвартай хөгжих нэг арга зам бол багш өөрөө сургалтын хөтөлбөр хийж, түүнийгээ байнга сайжруулах хэрэгжүүлэх явдал гэж үзэх болсон.

5. Багш хүн судлаач байх

6. Багш ажлын байранд хамтран сурах,

Орчин үед багш нар ажлын байрандаа өөрийгөө хөгжүүлэх ямар ямар арга зүй баримталдаг талаар болон багш ажлын байрандаа хөгжих ямар боломж, бололцоо байгааг цааш нь тодруулан авч үзье.

1. Багш нар хамтран ажиллах арга зүй

2. Багш сурагчидтайгаа хамтран ажиллах арга зүй

1. Багш нар хамтран ажиллах арга зүй

1. Орчин үед багш нар багаар ажиллах туршлага ихээхэн дэлгэрч байна.

• Заах арга зүйн нэгдлээр хамтран ажиллаж байгаа багш нар өөр өөрийн гэсэн онцлог чадвартай байгаа. Жишээ нь, шинээр ирсэн залуу багшийн хувьд ажлын туршлага дутмаг байгаа ч, олон жилээр ажилласан ахмад багшаас компьютер болон гадаад хэлний мэдлэг арай илүү сайн байгаа. Энэ тохиолдолд залуу багшийн хувьд ахмад багш нараасаа ажлын туршлага, мэдлэг, үр чадвараас нь суралцах, залуу багшийн хувьд гадаад хэл болон компьютерийн мэдлэгт нь туслаж, шаардлагатай гэж үзвэл зааж сургаж багш, шавийн барилдлагаар эргэх холбоо /ахмад багш сургагч, залуу багш сурагч/ байдлаар хамран ажиллаж болно.

• Нэг ангид хичээл заадаг багш нар нэг баг болж ажиллах ба ингэхдээ тухайн ангид хэн юу яаж заахаа хамтран хэлэлцэж, сургалтын агуулга, арга зүйгээ интеграцчилах, хамтран хичээл заах, хүүхдийн ачааллыг жигдрүүлэх зэрэг асуудлыг хамтын хүчээр шийдэж болно.

2. Багш сурагчидтайгаа хамтран ажиллах арга зүй

Багш өөрийн үйл ажиллагаандаа өөрөө дүн шинжилгээ хийж суралцах үйлийг сурагчидтайгаа хамтран явуулж чадвал алдаа оноо, амжилт

бүтээлийнхээ мөн чанарыг ухааран мэдэх боломж бүрдэж энэ нь өөрийгөө хөгжүүлэх гол хүчин зүйл нь болно.

Суралцах үйлийн гол утга нь сургахад бус харин сурах үйлийг сурагчтайгаа хамтран явуулж “багш, сурагч хоёр хичээл рүүгээ хамтдаа” гэсэн зарчмыг хэрэгжүүлэхэд оршиж байгаа бөгөөд ингэсэн нөхцөлд багшийн тасралтгүй суралцах хэрэгцээ үүснэ.

Багш сурагчидтайгаа “хамтран ажилласнаар” дараах үр дүн бий болно.

• Багш сурагчдын сэтгэх чадвар нээлттэй хөгжинө.

• Багш сурагчид өөрийн үүргээ ухамсарлана.

• Багш сурагчдын бүтээлч сэтгэлгээ хөгжих хөшүүрэг болж өгнө.

• Багш хичээл заахаар сурагчидруу бус сурагчидтайгаа хамт хичээл рүүгээ гэсэн зарчим үйлчилдэг болно.

Энэхүү хамтран ажиллах арга ухаан багш сурагчдын харилцаанд гарах өөрчлөлтөөс цаашдаа хамаарна.

“Хүн өөртөө үнэлгээ өгч чаддаггүй цорын ганц хөдөлмөр бол сурах хөдөлмөр байдаг” гэж Францын философич Декартын тодорхойлсноор багшийн хөгжил нь тасралтгүй сурч, өөрийгөө мэдэрч байхаас үүдэлтэйг асуудлын үндэс болгон тавих хэрэгцээ өнөөдөр ч байсаар, цаашдаа ч байх болно гэдэгт итгэж байна.

Нийгмийн реконструктивизм давамгайлсан конструктивизм төвтэй сурах /сургах онол нь багш боловсролын асуудлыг дараах үзэл баримтлалын дагуу авч үзэн, сайжруулах шаардлагатай байна.

• Нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүч нь боловсрол, боловсролын хөгжлийн цөм нь багшийн хөгжил байх

• Багш нь шинжлэх ухаан, технологийн өндөр хурдацтай хөгжил, даяаршлын эрин зуунд иргэддээ нийгмийн хэрэгцээ, шаардлага, хувь хүний авьяас сонирхолд нийцсэн боловсрол, ухаалаг, шударга, орчиндоо зөв зохицон амьдрах иж бүрэн чадвар эзэмшихэд нь найдвартай үйлчилгээ үзүүлж чадах сургалтын менежер байх

• Багш өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх, шинэ мэдээлэл, технологийг хүлээн авч ашиглах, тулгамдсан асуудалд судалгаа хийж үр дүнгээ хэрэглэх, сурах-сургах үйл явцыг зөв жолоодох мэдлэг, чадвар, харилцааны өндөр соёл, хамтарч ажиллах арга ухаан эзэмшсэн байх

• Багш нийгмийн болон суралцагчийн эрэлт хэрэгцээнд тохируулан боловсролын зорилго, агуулга, арга зүй, үнэлгээг шинэчлэгч хөгжүүлэгч байх

• Багш сургалтандаа хүн төрөлхтөний бүтээсэн соёл, иргэншлийн үнэт зүйлс, монголын соёл уламжлалыг оновчтой хослуулагч байх

• Багш сурах-сургах арга зүйг судлагдахуун буюу мэдлэг төвтэйгээс хувь хүний хэрэгцээ, сонирхол буюу үйл явц төвтэй болгон шинэчлэгч байх

• Суралцагч болон багш нь харилцан өөрсдийн

туршлага хуваалцан, бие биеэсээ суралцагч, тасралтгүй хөгжигч субъектууд байна.

- Сурах-сургах үйл явцын зорилтыг суралцагчийг сурах буюу мэдлэг бүтээх арга барилд сургах болгон өөрчлөгч байх

- Сургалтын аргазүйг суралцагч хувь хүн сурах-сургах үйл явцад идэвхитэй оролцож байж л өөрийн онцлог, чадавхидаа тохируулан, мэдлэгийг зохиомжлон бүтээдгийг тооцон шинэчлэгч байх

- Сурах-сургах үйл явц дахь субъектүүдийн харилцаанд суралцагчийн өөрөө сонголт хийх болон оюун санааны эрх чөлөөгөө олж авах үйл явцыг дэмжих замаа ардчилсан зарчмыг баримтлах

- Сургууль нь мэдлэгийг дамжуулагч биш, нийгмийн үнэт зүйлсийг бүтээгч, түүнийг өөрчлөн шинэчлэх үйл явцад тэргүүлэх байр суурь эзэлдгийг тооцож, өөрчлөлт шинэчлэлтийг тасралтгүй хийнэ.

- Сурах-сургах зорилго, зорилт, агуулга үйл явц, үр дүнг суралцагчийн эзэмшсэн чадвар, хувь хүний болон нийгмийн сэтгэл ханамжийн төвшингөөр үнэлнэ.

Багш боловсролын гүн ухаан, онол, үзэл баримтлалын дээрх өөрчлөлт нь боловсролын салбарын үндсэн ойлголтуудын агуулгыг цоо шинэ байдлаар эргэн харж, тусгайлан судлах шаардлагатай байна.

Багшийн хөгжлийн тулгамдсан асуудлууд:

- Багш нар мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөг бүтээлчээр хэрэгжүүлэх

- Багшийн орлогыг нэмэгдүүлэх замаар бүх хүч нөөцөө сургалтын ажилд зориулах эрх зүйн нөхцөл бүрдүүлэх

- Багш ажлын байран дээрээ өөрөө хөгжих хөтөлбөр боловсруулах

- Сургалт семинарыг сар бүр зохион явуулах

- Судалгааны ажлын арга барилд сургах, тасралтгүй судлаач байх

- Багшийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, төрөл бүрийн хөдөлмөр зохицуулалтын хэлбэрүүдийг туршиж үзэх, шинэчлэх хэрэгтэй байна.

Багш өөрийгөө хөгжүүлэхэд дараах бэрхшээлүүд хамгийн их тулгардаг байна. Үүнд:

1. Ямар нэгэн хурал, семинар, сургалтад оролцоход хичээлийн цаг давхацдаг
2. Эх хэл дээрх мэргэжлийн ном, эх сурвалжийн хүртээмж муу
3. Эх хэл дээрх Боловсрол судлалын ном, гарын авлага хангалтгүй
4. Гадаадын хуралд илтгэл тавих, оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй
5. Өөрийгөө хөгжүүлэхэд техник хэрэгслийн хүртээмж муу
6. Эрдэм шинжилгээний өгүүллийг гадаадын мэргэжлийн зэрэглэл өндөртэй сэтгүүлд хэвлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй
7. Өөрт хэрэгцээтэй сургалт хөтөлбөр байхгүй байх
8. Сургалтаас гадуур захиргааны ажилд багш нар

цаг их зарцуулдаг

9. Цагийн хуваарилалт, зохицуулалт багш нарт ачаалал үүсгэдэг

10. Хамтын ажиллагаа, тэнхим хоорондын уялдаа сул

11. Удирдлагын тогтвортой бус байдал нь сургалтын бодлого, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг

12. Багтаамж багатай өрөөнд олон багш суудаг нь оюутанд зөвлөгөө, давтлага өгөх боломж хязгаарлагддаг гэхдээ багш хөгжих боломж, гарц байсаар байна.

Багш ажлын байрандаа хөгжих боломжууд:

Багшийн ажлын байранд хөгжих нь дараах 2 арга хэлбэрээр явагдана.

1. Улс, нийгмээс багшийг хөгжүүлэх арга хэмжээ

2. Багш өөрийгөө хөгжүүлэх арга хэмжээ

Үүний хоёр дахь арга хэлбэр болох багшийн өөрийгөө хөгжүүлэх арга хэмжээний талаар цааш нь тодруулан авч үзье. Багшийн өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа нь олон чиглэлтэй.

- Багш хүн өөрийнхөө мэдрэмжийг хөгжүүлэх,

- Сурган хүмүүжүүлэх ажилдаа хандах хандлагаа өөрчлөх,

- Багш өөрийнхөө сурган хүмүүжүүлэх ёс зүйн харилцааны соёлоо төгөлдөржүүлэх,

- Багш хүн судлаач байх

- Багш ажлын байранд хамтран сурах

Багш хөгжих үндэсэн нөхцөл бол сэтгэхүйгээ өөрчилж хөгжих хэрэгцээгээ өөртөө бий болгох ба гадаад хэлний мэдлэгээ сайжруулах нь мэдээллийг хүссэн цагтаа ямар ч мэдээллийг авах боломж нээгдсэн. Багшийн хөгжил, сургалтын хэрэгцээг сургуулийн удирдлага, багш нар хамтран тодорхойлж, тухайн сургууль багшийн хөгжлийн ажлыг хэрхэн зохион байгуулж, удирдан чиглүүлж буй байдал, багш нарын хандлага хэрхэн өөрчлөгдөн шинэчлэгдэж буй байдал зэрэг БАГШИЙН ХӨГЖИЛ-д ихээхэн нөлөөтэй байна. Багш хөгжихийн хэрээр багшийн өөрийн мэргэжлийн мэдлэг, заах арга, ур чадвар дээшилж, улмаар боловсролын чанарт төгс өөрчлөлт гарч, нийгмийн хөгжилд түлхэц болох нь тодорхой юм.